



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 435

Улаанбаатар хот

“Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад  
улсад гаргах үнэт цаасыг мэдэгдэх тухай журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6.3, 17.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:


1. “Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад гаргах үнэт цаасыг мэдэгдэх тухай журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Дээрх журам батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 83 дугаар тогтоолоор баталсан “Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээдээс гадаадын үнэт цаасны зах зээлд гаргах үнэт цаасыг бүртгэх журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 06 тоот тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 6.8 дахь хэсгийг хүчингүй болгосугай.

4. Батлагдсан журмын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000477